

**“ХӨДӨӨ АЖ АХУЙН БИРЖ” ХХК-ИЙН  
БАЙНГЫН ГИШҮҮНД ТАВИГДАХ ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

**НЭГ. НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү шалгуур нь “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”, “Биржийн үйл ажиллагааны ерөнхий журам” болон бусад холбогдох хууль, эрх зүйн баримт бичгийн хүрээнд арилжаа зохион байгуулах, биржийн үйл ажиллагааны найдвартай, эрсдэлгүй байдал, үндсэн зарчмыг хангахад чиглэсэн үндсэн шаардлага мөн.
- 1.2. Энэхүү шалгуурыг Биржийн гүйцэтгэх удирдлага батлах бөгөөд нэмэлт, өөрчлөлт орсон тохиолдолд тухай бүр нийтэд мэдээлнэ.

**ХОЁР. ШАЛГУУР ҮЗҮҮЛЭЛТ**

- 2.1 Байнгын гишүүн нь дараах үндсэн шаардлагыг хангасан байна.
  - 2.1.1. “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн 10.2-т заасны дагуу Үндэсний хөрөнгө оруулалт давамгайлсан Монгол улсад үйл ажиллагаа явуулах эрх бүхий хуулийн этгээд байх;
  - 2.1.2. “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн 11.2.3-т заасны дагуу бараа, түүхий эдийг хүлээн авах, хадгалах, бэлтгэх зориулалтын итгэмжлэгдсэн агуулахтай байх, эсвэл итгэмжлэгдсэн агуулах бүхий этгээдтэй гэрээ байгуулсан байх;
  - 2.1.3. “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн 10.4-т заасны дагуу Санхүүгийн зохицуулах хорооны шалгуурыг хангасан байх;
  - 2.1.4. Зуучлалын үйл ажиллагаа явуулах, харилцагчдад биржийн үйл ажиллагааг танилцуулах боломж бүхий ажлын байртай байх;
  - 2.1.5. Клирингийн эрхтэй гишүүн Клиринг төлбөр тооцооны журмын 3.12, 3.13-т заасан барьцаа хөрөнгө байршуулах /Зөвхөн клирингийн эрхтэй гишүүнд хамаарна/;
- 2.2 Байнгын гишүүн нь хүний нөөцийн дараах шаардлагыг хангасан байна. Үүнд:
  - 2.2.1. Байнгын гишүүн нь “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль”-ийн 5.1.5-д заасны дагуу сургалтад хамрагдаж, доор дурдсан брокерын эрх авсан байх;
  - 2.2.2. Хөдөө аж ахуйн гаралтай бараа түүхий эдийн зах зээлийн тухай болон хууль эрх зүйн мэдлэгтэй, харилцагчдад биржийн зах зээлийн мэдээлэл өгөх, тайлбарлах, компанийг төлөөлж биржтэй харилцах, дотоод хяналтыг хэрэгжүүлэх ажилтан;
  - 2.2.3. Арилжааны брокер буюу Биржийн арилжаанд оролцох;
  - 2.2.4. Захиалгын брокер буюу харилцагчийн захиалгыг бүртгэж, арилжааны програмд оруулах;
  - 2.2.5. Барааны брокер буюу агуулах дахь барааны чанар, стандарт хариуцагч брокер.

## ГУРАВ. БҮРДҮҮЛЭХ БИЧИГ БАРИМТ


№	Бүрдүүлэх бичиг баримт	Шинээр элсэх	Гэрээ сунгах
1	Байнгын гишүүнээр элсэх, гэрээ сунгах өргөдөл /Хавсралт 2/*	✓	✓
2	Биржийн гишүүний анкет /эх хувьтай тулгах/ /Хавсралт 3/*	✓	
3	Хуулийн этгээдийн Улсын бүртгэлийн гэрчилгээ*/эх хувьтай тулгах/	✓	
4	Улсын бүртгэлийн ерөнхий газраас авсан, компанийн хувьцаа эзэмшигчдийн лавлагаа, охин компанид хөрөнгө оруулалт хийсэн толгой компанийн лавлагаа*	✓	
5	Агуулахын эзэмшигчийг нотлох бичиг баримт эсвэл итгэмжлэгдсэн агуулахтай хамтран ажиллах гэрээ /эх хувьтай тулгах/	✓	✓
6	Санхүүгийн зохицуулах хорооны тусгай зөвшөөрөл	✓	✓
7	Эрх бүхий албан тушаалтан, ажилтнуудын анкет /Хавсралт 4/* нийгмийн даатгалын дэвтрийн хуулбар	✓	
8	Брокерын эрх авсан ажилтнуудын үнэмлэх	✓	
9	Ажилтантай байгуулсан нууцлалын гэрээ /эрх бүхий ажилтны гарын үсэг бүхий албан бичиг/	✓	✓
10	Байнгын гишүүний үйл ажиллагаа явуулах байрны үл хөдлөх хөрөнгийн гэрчилгээ эсвэл түрээсийн гэрээ*	✓	
11	Сүүлийн нэг жилийн аудитлагдсан санхүүгийн тайлан, үйл ажиллагаа эхэлж байгаа бол эхлэлтийн тайлан, Санхүүгийн тайлангийн нэмэлт тодруулга	✓	
12	Санхүүгийн бичиг баримт дээр гарын үсэг зурах эрх бүхий этгээдийн гарын үсгийн нотариатаар баталгаажсан хувь /Хавсралт 5/	✓	✓

\* - Гэрээ сунгахад дээр дурдсан бичиг баримтад өөрчлөлт орсон бол Гишүүнчлэлийн албанд мэдэгдэнэ.

Компьютер, тоног төхөөрөмж, холболтын шалгуур

1. Байнгын гишүүн нь хуулиар хүлээсэн үүргээ биелүүлэхэд шаардлагатай ажлын байртай байх ба харилцагчийг хүлээн авч үйлчлэх танхимыг тусгаарлаж, үйлчилгээний танхимын зориулалтаар тохижуулсан байна.
2. Биржээс заасан дараах техникийн шаардлагыг хангасан компьютер, техник хэрэгслийг ажлын байранд суурилуулсан байна. Үүнд:
  - 2.1. Арилжааны бүрэн эрхтэй програм;
  - 2.2. Арилжааны хагас эрхтэй програм;
  - 2.3. Харилцагчийн бүртгэлийн програм;
  - 2.4. Агуулахын бүртгэлийн програм;
3. “Back office” програм суулгахад дараах шаардлагыг тавина. Үүнд:
  - 3.1. Процессор (CPU): Intel core i5, 3.0GHz ба түүнээс дээш
  - 3.2. Нөөцлөх санах ой (Cache): 4MB ба түүнээс дээш
  - 3.3. Түр санах ой (RAM): 8GB ба түүнээс дээш
  - 3.4. Хатуу диск (HARD DISK): 500 GB ба түүнээс дээш
  - 3.5. Нэмэлт график карт (EXPANSION GRAPHICS CARD), 2 буюу түүнээс дээш дэлгэц холбоход ашиглана
  - 3.6. Үйлдлийн систем (OS): Windows 7 буюу түүний дараагийн хувилбар.
4. Ажлын байрны нэмэлт компьютер: Үзүүлэлт- Windows 7 үйлдлийн системтэй, Микрософт оффис програмын 2010 хувилбарыг саадгүй ажиллуулах хүчин чадалтай байна.
5. Биржийн арилжааны мэдээг харилцагчид түгээх мэдээллийн дэлгэц, хэвлэх төхөөрөмж;
6. Интернет холболт.

## А брокерийн компани (микомийн интернэттэй)



Ханшийн мэдээлэл гарах зурагт (1)-ыг хүлээн авах брокер (3)- той холбоход HDMI залгуур ашиглана.

— дотоод сүлжээний кабель

- - - телефоны шугам

- Орон нутгийн брокерын компаниуд хамгийн багадаа **1Mbps хурдтай** интернэт ашиглан холбогдох шаардлагатай. Интернетийн хурд нь **тасалдал хамгийн багатай** байх шаардлагатай бөгөөд **программын ажиллагаа** үүнээс шууд хамаарна.

*Жич: Эдгээр тоног төхөөрөмжийг ажлын байранд байрлуулсан байна.*

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн  
Гишүүнчлэлийн албанд  
өргөдөл гаргах нь

20... он ... сар ..... өдөр

Байнгын гишүүнээр элсэх тухай

..... ХХК нь Хөдөө аж ахуйн биржийн байнгын гишүүнээр элсэхэд тавих шалгуур нь биржийн байнгын гишүүнээр элсэхэд баримтлах үндсэн үзүүлэлт мөн болохыг хүлээн зөвшөөрч, тус шалгуурын шаардлагыг бүрэн хангаж, холбогдох бичиг баримтыг биржийн Гишүүнчлэлийн албанд хүлээлгэн өгсөн болно.

Энэ компани нь Монгол улсын холбогдох хууль тогтоомж, “Хөдөө аж ахуйн гаралтай бараа, түүхий эдийн биржийн тухай хууль” болон Биржийн үйл ажиллагааны журам дүрмийг чанд сахин биелүүлэхээ илэрхийлж, Хөдөө аж ахуйн биржийн байнгын гишүүн оролцогч болох хүсэлтэй байгаа тул, шийдвэрлэж өгнө үү.

Өргөдөл гаргасан

.....ХХК-ийн

захирал ...../ /

**БИРЖИЙН ГИШҮҮНИЙ АНКЕТ**

1. Компанийн бүтэн нэр /Компанийн дүрмийн дагуу/  
.....
2. Компанийн товч нэр /Компанийн дүрмийн дагуу/  
.....
3. Компанийн бүтэн нэр англи хэлээр /Хэрэв компанийн дүрэмд заагаагүй бол практик дээр хэрэглэдэг нэр/  
.....
4. Компанийн товч нэр англи хэлээр /Хэрэв компанийн дүрэмд зааж өгөөгүй бол практик дээр хэрэглэдэг нэр/  
.....
5. Улсын бүртгэлийн гэрчилгээний дугаар  
.....
6. Улсын бүртгэлийн гэрчилгээ авсан огноо  
.....
7. СЗХ-ны тусгай зөвшөөрлийн гэрчилгээний дугаар  
.....
8. Компанийн байршлын хаяг  
.....  
.....
9. Компанийн шуудангийн хаяг  
.....
10. Утас  
.....
11. Факс  
.....
12. И-мэйл хаяг  
.....
13. Компанийн цахим хуудасны хаяг  
.....
14. Ажиллах цагийн хуваарь  
.....
15. Харилцах банк  
.....
16. Дансны дугаар  
.....
17. Регистрийн дугаар  
.....
18. Мэргэжлийн холбоо, бусад биржийн гишүүн эсэх  
Тийм                      Үгүй                      (дугуйлах)  
.....

Гарын үсэг ..... /  
тамга

Албан тушаал .....


“.....” ХХК-ийн  
ЭРХ БҮХИЙ АЛБАН ТУШААЛТАН, БРОКЕРУУДЫН АНКЕТ

1. Ургийн овог \_\_\_\_\_  
 2. Эцэг, (эхийн) нэр \_\_\_\_\_  
 3. Нэр \_\_\_\_\_  
 4. Хүйс \_\_\_\_\_ эр / эм

5. Төрсөн он, сар, өдөр

6. Гэрийн хаяг \_\_\_\_\_

7. Регистрийн дугаар              
 (иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргана)



8. Боловсрол /ерөнхий боловсролын сургуулийг оролцуулан бичнэ/

*Хүснэгт 1*

№	Төгссөн сургууль	Эзэмшсэн мэргэжил	Элссэн он	Төгссөн он	Диплом, гэрчилгээний дугаар
1					
2					
3					

9. Ажлын туршлага

*Хүснэгт 2*

№	Байгууллагын нэр	Албан тушаал	Ажилд орсон огноо	Ажлаас гарсан огноо
1				
2				
3				
4				

Хуулийн этгээдийн нэр \_\_\_\_\_

*/Тамга дарж баталгаажуулах/*

Эрхэлж буй ажил \_\_\_\_\_

Гарын үсэг \_\_\_\_\_ /

20....он ....сар ....өдөр

**“.....” ХХК-ийн САНХҮҮГИЙН БАРИМТАД ГАРЫН ҮСЭГ ЗУРАХ  
ЭРХ БҮХИЙ ЭТГЭЭДИЙН  
ГАРЫН ҮСГИЙН БАТАЛГААНЫ МАЯГТ**

оны сарын өдөр

<b>Гишүүн байгууллагын нэр</b>	
<b>Байгууллагын албан ёсны хаяг</b>	
<b>Утасны дугаар И-мэйл хаяг</b>	
<b>Харилцагч банкны нэр, дансны дугаар (арилжааны төлбөр тооцоо гүйцэтгэхэд ашиглагдах данс)</b>	1. 2.

“Хөдөө аж ахуйн бирж” ХХК-ийн гишүүн ..... компанийг төлөөлж, арилжааны төлбөр тооцоог гүйцэтгэхээр ..... ажилтай ..... овогтой .....-д итгэмжлэл олгон, хүлээн зөвшөөрч байгааг баталгаажуулан гарын үсгээ зурав.

№	Данс эзэмшигчийн нэр	Регистрийн дугаар	Баталгаат гарын үсэг	Тамга
1				
	Итгэмжлүүлэгч этгээдийн нэр	Регистрийн дугаар	Баталгаат гарын үсэг	Тамга
1				

**Гарын үсгийн баталгааны маягтыг хүлээн авсан**

“ХААБирж” ХХК-ийн гишүүнчлэлийн албаны ажилтан:...../ /

**Хүлээн авсан огноо**

- \* Санхүүгийн баримт гэдэгт биелэгдсэн хэлцлийн дагуу байгуулагдах гэрээ, дэнчин буцаах хүсэлтийг хэлнэ.
- \* Иргэний үнэмлэхийн хуулбарыг хавсаргана /данс эзэмшигч болон итгэмжлүүлэгч этгээд/